

ХАВСРАЛТ-___ ТӨСЛИЙН БАРИЛГЫН АЖЛЫН
УРЬДЧИЛГАА САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ГЭРЭЭ

2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр № ХАГ-19/7469/10 Улаанбаатар хот

Нэг талаас “Монголын төмөр зам” ТӨХК (цаашид “МТЗ” ТӨХК гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл,

Нөгөө талаас Монгол Улсын тохируулагч агентлаг Зэвсэгт хүчний жанжин штаб (цаашид “ЗХЖШ” ХК гэх), түүнийг төлөөлж Дарга А.Ганбат нар

(цаашид хамтад нь “Талууд”, аль нэг талыг дангаар нь “Тал” гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон энэхүү Санхүүжилтийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний гол нөхцөл

- 1.1. Талууд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн шууд удирдлага дор Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл (цаашид Төсөл гэх)-ийн бүтээн байгуулалтыг 2019 оны 05 дугаар сард эхлүүлэхээр болсон.
- 1.2. “МТЗ” ТӨХК нь барилгын ажлыг эхлүүлэхэд эхний ээлжинд шаардагдах санхүүжилтэд зориулан Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан эх үүсвэрээс төвлөрүүлсэн Төслийн зориулалтын хөрөнгөөс ЗХЖШ-д 8,900,000,000.0 (найман тэрбум есөн зуун сая) төгрөгийн урьдчилгаа төлбөр олгох бөгөөд ЗХЖШ нь энэхүү урьдчилгаа төлбөрийг зөвхөн энэ гэрээнд заасан нөхцөл, зориулалтаар захиран зарцуулж, эргүүлэн төлнө.
- 1.3. ЗХЖШ нь ажлын гүйцэтгэлийн сар бүрийн хянан баталгаажигдсан төлбөрийн 15 хувийг суутгуулах замаар урьдчилгаа төлбөрийг эргэн төлнө.
- 1.4. Хэрэв урьдчилгаа төлбөр аливаа шалтгаанаар эргэн төлөгдөөгүй тохиолдолд ийнхүү төлөгдөөгүй урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл нь “ЗХЖШ”-аас “МТЗ” ТӨХК-д төлөх ёстой төлбөрт тооцогдоно.

Хоёр. “ЗХЖШ”-ын хүлээх үүрэг

- 2.1. ЗХЖШ нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэнэ. Урьдчилгаа төлбөрийг энэхүү ажлын зориулалтаар захиран зарцуулна.
- 2.2. ЗХЖШ нь урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг нэхэмжлэхийн хамт “МТЗ” ТӨХК-д ирүүлнэ.

Гурав. "МТЗ" ТӨХК-ийн хүлээх үүрэг

- 3.1. "МТЗ" ТӨХК нь Гэрээний 1.3-т заасан урьдчилгаа төлбөрийг ЗХЖШ-д олгох бөгөөд Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газрын Төрийн сан банк дахь 100900014444 тоот харилцах дансанд энэ гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор шилжүүлнэ.
- 3.2. Гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-д заасан барилгын ажлын гүйцэтгэлийн төлбөрөөс энэхүү урьдчилгаа төлбөрийг энэ гэрээнд заасан хувь хэмжээгээр суутган авна.

Дөрөв. Бусад

- 4.1. Талууд гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 4.2. Гэрээ байгуулах, гэрээ хэрэгжих явцад Талууд хоорондын харилцаа, аливаа мэдээллийг солилцохдоо холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нууцлалыг чанд мөрдөж ажиллана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"МТЗ" ТӨХК-ийг төлөөлж:




Б.ЦЭНГЭЛ

ЕРӨНХИЙ НИЯГТАН БОДОРЧ

Д.ДАВААДОРЖ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн
чөлөө 51
Утас: 51265914, 11452933

"ЗХЖШ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:



А.ГАНБАТ

ЗЭВСЭГТ ХУЧНИЙ БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Г.БАТЦУУРЬ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-5 хороо, 13-р
хороолол, Нарны зам-62,
Утас: 70006622, 70106655

